

Ц.Цэрэндаш ( Ph.D.)

Хүн Судлалын Үндэсний Төвийн Эрдэм Шинжилгээний Ахлах Ажилтан.  
О.Сүхбаатар (Хүн Судлалын Үндэсний Төвийн Эрдэм Шинжилгээний  
Ажилтан)

### **Угсаатнуудын байршил, шилжих хөдөлгөөний үндсэн төрх**

*Монгол улс нь олон ястны өлгий нутаг бөгөөд одоогоор Монгол, Түрэг 2 угсааны 20 шахам ястан, угсаатнууд оршин сууж байна. Энэхүү ажилд, судлаачид Монгол улсад амьдарч буй хэл, соёл, амьдралын хэв маягаараа өвөрмөгц, онцлог ялгаатай олон ястан үндэстнүүдийн байршил, тархалт, шилжих хөдөлгөөн, тэдгээрийн түүхийн талаар сонирхолтой судалгаа хийжээ. Монгол улсын хүн амын 93.5 хувийг эзэлдэг монгол угсааны үндэстэн, ястнууд төдийгүй тоо хэмжээг нь ч бүрэн гаргахад бэрхшээлтэй олон ястан үндэстнүүдийн байршил, тархалтыг Монгол улсын одоогийн засаг захиргааны нэгж аймгуудаар нарийвчлан судалсан судалгааны ажлын дэлгэрэнгүй үр дүнг Уншигч та доорх бүтээлээс уншина уу.*

Монгол улс олон ястны өлгий нутаг билээ. Одоогоор Монголд хоёр угсааны /монгол, түрэг угсаа/ 20 шахам ястан угсаатнууд оршин сууж байгаа бөгөөд тэдний байршил, нутагшлын ерөнхий дүр төрхийг Зураг 1-д үзүүлэв.

Монгол улсад угсаатан, ястнуудын байршил, нутагшил ихээхэн онцлогтой бөгөөд Монгол Улсын хүн амын 93.5 хувийг эзлэх монгол угсаатан улсын нутаг, дэвсгэрийн 97%-д тасралтгүй үргэлжилсэн, жигд дэлгэмэл нутагшлаар оршин сууж байна.

Монголчуудаас хамгийн олон тоотой нь болох **халхчууд** нь 1585.4 мянга гаруй бөгөөд нийт монгол угсаатны 81%-г эзэлж, 1.350 мянган хавтгай дөрвөлжин километр нутагт дагнан нутагладаг.

Халхчуудын тархалтыг авч үзвэл Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Булган, Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Хөвсгөл аймгийн ихэнх сумд, Ховд аймгийн Буянт, Дарви, Цэцэг, Чандмань сумд, Мөст сумын зүүн хагас, Увс аймгийн Баруунтуруун, Завхан, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан сумдын нутаг хамаарагдана.

Халхчуудын тасралтгүй үргэлжилсэн дэлгэмэл нутагшил үүсгэн оршин суух нутагт дунджаар 10 хавтгай дөрвөлжин километр нутагт 12 хүн ногдох нягтшилтай боловч нутаг тус бүрт хүн амын нягтшил харилцан адилгүй байна. Говийн бүсэд 10 хавтгай дөрвөлжин километр нутагт 2 хүн ногдож байхад, ойт хээрийн бүсийн зарим сумдад (Өвөрхангайн Хархорин, Хужирт зэрэг) 30 хүн ногддог.

Архангай, Өвөрхангай аймгийн халхчуудын оршин суух нутагт хөдөөгийн хүн амын нягтшил Монгол Улсад хамгийн нягт байдгаараа онцлог юм. Мөн говийн бүсийн халхчууд бусад угсаатнаас хамгийн сийрэг суурьшлаараа ялгарч байдаг.

Халхчуудын нутаглах газар нутгийн талбай их, хүн амын нягтшил харилцан адилгүй, тэдний нутаглаж байгаа төв ба умард нутаг дахь үйлдвэрлэх

хүчний хөгжлийн хурдац, төвлөрөл Монголдоо хамгийн өндөр байсантай уялдаж хүн амын шилжих хөдөлгөөн эрчимжиж, хүн амын байршилт, нутагшилтанд орон нутаг, аймгийн төдийгүй улс орны хэмжээний өөрчлөлт гарчээ. Халхчуудын 40% нь шилжих хөдөлгөөнд хамрагдаж, улс орны аль ч хэсэгт оршин сууж байсан хэдий ч шилжигсдийн ихэнх нь хотууд, хот маягийн суурингууд болох Төв, Сэлэнгэ, Булган аймгийн газар тариалан голлон эрхэлдэг сумдад шилжин суурьшжээ. Халхчуудын энэхүү байршил, шилжих хөдөлгөөн нь Монголчуудын шилжих хөдөлгөөний төрх байдлыг тод хадгалсан байдаг.

**Сартуул** ястны хүн ам 25,0 мянга орчим бөгөөд тэд Завхан аймгийн Сонгино, Сантмаргац, Ургамал, Завханмандал, Эрдэнэхайрхан, Дөрвөлжин сумдын бүх нутаг Завхан аймгийн Яруу, Түдэвтэй, Увс аймгийн Завхан сумын бараг бүх нутаг, Завхан аймгийн Алдархаан, Ховд аймгийн Дөргөн, Чандмань, Говь-Алтай аймгийн Хөх-Морьт, Увс аймгийн Зүүнхангай, Цагаанхайрхан, Өндөрхангай сумдад цөөн тоотой оршин суудаг. Тэдний хэл аялгуу зан заншил, хөдөлмөрийн дадлага нь халхчуудынхаас төдийлөн ялгагдахгүй. Сартуулчуудын 1/3-ээс илүү нь улсын зэрэглэлд багтах том хотууд болон улс орны төвийн бүсэд шилжин суурьцсан билээ. Тэдний нутагшил халхчуудын нутагшлын хэвшлээс огт ялгагдахгүй гэж болно.

**Хотгойд** ястны хүн ам нь 25.0 мянга орчим бөгөөд Завхан аймгийн Нөмрөг, Баянхайрхан, Баянтэс, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул, Арбулаг, Бүрэнхайрхан, Төмөрбулаг сумдын нутаг, Түнэл, Тосонцэнгэл сумдын зарим хэсгээр оршин суудаг. Хотгойд нар зан заншил, хөдөлмөрийн дадал, нутагшлын хэвшлээр халхчуудтай адил боловч, ярианы аялгуунд ойрд, буриад үг аялгуу ажиглагддаг.

**Илжгэн сартуул** буюу илжгин халхчууд Увс аймгийн Баруунтуруун (сүүлд сангийн аж ахуй байгуулах үед баяд, дөрвөд нар нэлээд ирж суурьшсан), Өндөрхангай, Цагаанхайрхан, Зүүнхангай сумдад оршин сууна. Хэл яриа, зан заншил, хөдөлмөрийн дадлын хувьд халхчуудаас ялгарах зүйл бараг байхгүй. Тэдний ихэнхи нь өөрсдийгөө сартуул хошууныхантай нэг гарал үүсэлтэй гэж үздэг байхад нөгөө хэсэг нь халхаас, тухайлбал одоогийн Архангай аймгийн нутгаас нүүн ирж нутагшсан халхчууд гэж ярьдаг.

**Ариг урианхайчууд** Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр, Цагаан-Уул сумдад оршин суух бөгөөд хэл яриа, зан заншил, хөдөлмөрийн дадал нь халхчуудынхаас бараг ялгаагүй. Оршин суугаа нутаг нь ой ихтэйгээс шалтгаалж модны ажилд бага зэрэг илүү дадалтай нь ажиглагдана.

Сартуул, Хотгойд, Илжгэн халх, Ариг урианхай нар өөрсдийгөө халхчууд гэж үздэг. Халх гэж бүртгүүлдэг учир тэдний тоог бүртгэж тооцсон мэдээ албан ёсоор гараагүй байна, гарах ч бололцоо байхгүй. Харин зөвхөн судалгаанд харгалзах тойм тоо гарах боломж бий. Бидний судалгааны харьцангуй жишилтээр бол сартуулчууд 30 орчим мянга, хотгойдууд 20-25 мянга орчим, илжгэн халхчууд 10-12 мянга, ариг урианхайчууд 3-4 мянга гэж тоймлож болно. Гэхдээ энэ бол судлаачын ерөнхий тойм жишилтэнд хамааруулж болох тун ч тоон баримжаа гэдгийг давтан хэлье. Сартуул, Хотгойд, Илжгэн халхчуудын нутаг дэвсгэртээ оршин суух нягтшил нь Монголын өнөөгийн хүн амын дундаж нягтшлаас арай илүү буюу харьцангуй

нягт байдаг бол Ариг урианхайчуудын хүн амын нягтшил ихээхэн сийрэг байдаг. Нутаглах нийт нутагт нь харьцуулбал ариг урианхайн нягтшил сийрэг мэт харагдавч хөдөө аж ахуйн эдэлбэр газартай нь харьцуулбал ихээхэн нягтшилтайд хамааруулна.

Халх аялгуутанд хамааруулдаг угсаатны нэгэн том нэгдэл бол **даригангачууд** юм. Даригангачууд нь 29.9 мянга гаруй бөгөөд гарал үүслийн хувьд Монголын олон хошуудаас сүрэгчнээр цугларч нутагшсан халх аялгуутнууд юм. Даригангачууд одоо Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон, Наран сумдын бүх нутаг, Халзан, Асгат сумын нэлээд нутагт оршин суудаг.

Даригангачуудын 60-аад хувь нь энэхүү нутагшлынхаа хүрээнд (35 мянган хавтгай дөрвөлжин километр орчим) 10 хавтгай дөрвөлжин километр нутагт 7 хүн оногдох нягтшилтай оршин суудаг. Даригангачуудын 10 гаруй хувь нь Улаанбаатар хотод, 10-аад хувь нь Дархан, Эрдэнэт, Төв, Сэлэнгэ аймагт, 5 хувь нь Дорнод аймагт, 20-иод хувь нь Баруун-Урт хотод оршин сууж байна.

Монгол угсаатан ястны нэг болох **буриадууд** нь 35,4 мянга бөгөөд Дорнод аймгийн хойт талын 45 орчим хавтгай дөрвөлжин километр нутагт оршин сууж байна. Нутагшлын үргэлжилсэн талбайн хэмжээгээр тэд зөвхөн халхчуудын дараа орох боловч 10 хавтгай дөрвөлжин километр талбайд 5 хүн оршин сууж байгаа тул хамгийн сийрэг нягтшилтай угсаатны нэг болно.

Буриадуудын 40-өөд хувь нь Дорнод аймгийн Баян-Уул, Дашбалбар, Хэнтий аймгийн Дадал, Батширээт сумдын бүх нутаг, Хэнтий аймгийн нутгийн хойт хагас, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын ихэнх нутаг, Чулуун хороот сумын баруун хэсэг, Норовлин, Булган аймгийн Тэшиг, Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сум, Ханх хорооны зарим хэсэгт оршин сууж байна.

Буриад ястны хүн амын 1/3 хэсэг нь Улаанбаатарт, 1/3 нь Өндөрхаан, Дархан, Сүхбаатар, Эрдэнэт, Булган, Мөрөн хотод сууж байна. Сүүлийн үеийн хүн амын судалгаагаар буриадуудын нийт хүн амд эзлэх хувийн жин нэлээд буурсан нь нэг талаар буриадууд хот сууринд шилжин суурьшиж, хэл ярианы хувьд халхжиж байгаа, нөгөө талаас нэг гэр бүлд оногдох хүүхдийн тоо цөөн байдагтай холбоотой гэж үзэж болно. 1920 –иод оны сүүлчээр Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймагт Зөвлөлт буриадаас шилжин ирж суурьшсан буриадууд болон тэдний үр хүүхдийн ихэнх хот сууринд шилжин суурьшиж, одоо эдгээр аймгийн буриадуудын үргэлжилсэн нутагшилтай нутаг үндсэндээ тодорхой ялгагдахааргүй болжээ.

Монгол хэлтний дотор 2-р байрыг ойрд аялгуутан эзэлдэг. Ойрд аялгуутан Дөрвөд, Баяд, Торгууд, Алтайн урианхай, Захчин, Өөлд, Мянгад нар буюу улсын нийт хүн амын 8 хувь нь хамаарагдана. Тэдний оршин суух Ховд, Увс, Баян-Өлгий аймагт ажиллах хүчний нөөц хүрэлцээтэй байсан учир эдгээр аймгаас хамгийн олон хүн улс орны төв хэсэгт болон хот сууринд шилжин суурьшжээ. Ойрдууд Төв, Сэлэнгэ, Булган, Дорноговь зэрэг аймгуудад хамгийн олноор шилжин суурьшсан нь нэлээд онцлог юм.

Баруун монгол буюу Ойрдын бүлэглэлээс хамгийн олон нь **дөрвөдүүд** бөгөөд хүн ам нь 55,5 мянга гаруй байдаг. Дөрвөдүүд Увс аймгийн Бөхмөрөн, Давст, Өлгий, Өмнөговь, Сагил, Түргэн, Ховд сумдын бүх нутаг, Ховд аймгийн Дөргөн сумын ихэнх нутаг, Увс аймгийн Наранбулаг сумын баруун хагас, Тариалан сумын нэлээд нутагт нэлэнхүй нутагшил үүсгээд амьдарч байна.

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт 1930-аад он хүртэл дөрвөд нар дагнан нутаглаж байсан боловч, 1950-иад оноос эхлэн шилжин суурьшсаар одоо энд цөөхөн өрх үлджээ. Дөрвөдүүд дангаараа нутаглах 30 мянган хавтгай дөрвөлжин километр нутагт 25 мянга орчим хүн сууж, хүн амын нягтшил нь 10 хавтгай дөрвөлжин километр газарт 8 хүн ногдож байна.

Дөрвөдүүдийн 64,5 хувь нь Увс аймагт, 25 хувь нь Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод, 10-аад хувь нь Төв, Сэлэнгэ аймгийн төв болон бусад аймгуудын төвд шилжин суурьшжээ.

**Баядууд** Увс аймгийн Зүүнговь, Малчин, Хяргас, Тэс сумдын бүх нутаг, Наранбулаг сумын зүүн хагаст нэлээд нягт суурьшилтай оршин суудаг. Баядуудын нутаглах талбай 16 мянган хавтгай дөрвөлжин километр бөгөөд 10 хавтгай дөрвөлжин километр нутагт 17 хүн ногдоно. Баядууд 1980-аад он хүртэл гадагш /бусад аймаг хотод/ шилжин суурьших нь бага, хүн ам нь хөдөөд зонхилон суудаг байсан. Баядууд 1956-1989 онд 2,77 дахин өссөн нь хүн амын өсөлтөөс хол давж байна. Улсын хүн амд баядуудын хувийн жин 1,9 байснаа 2 хувь болж өсжээ. 1980-аад оноос баядууд Улаанбаатар, Улаангом, Эрдэнэт, Дархан хот, Төв, Сэлэнгэ аймагт шилжин суурьших нь эрчимжжээ. Баяд нар орон нутгийнхаа зан заншил, дадлаа одоо хүртэл хадгалсан байдаг.

Баруун монгол бүлэглэлийн нэг томоохон ястан нь **захчингууд** юм. Захчин нарын хүн ам нь 23 мянга орчим бөгөөд Монгол Алтайн ар өвөр, хажуу хөндийгөөр Ховд аймгийн Алтай, Зэрэг, Үенч сумдын бүх нутаг, Мөст сумын нэлээд нутгийг хамарсан тархалттай байдаг. Нутаг дэвсгэрийн хэмжээ нь 29 мянган хавтгай дөрвөлжин километр бөгөөд 10 хавтгай дөрвөлжин километр нутагт 6 хүн ногдохоор тархан байрладаг. Захчин нарын 1/4 нь Ховд аймаг, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод, Төв Сэлэнгэ аймагт шилжин суурьшжээ.

Өнгөрсөн зууны эхэн хүртэл Алтайн нурууны ар, өврөөр нэлэнхүйд нь нутаглаж, зөвхөн Монгол хэлээр ярьдаг байсан **урианхайчууд** нь /Алтайн урианхай ч гэдэг/ өөлд, торгууд нартай нягт харилцаатай байв. Урианхай хүн ам 13,5 мянга бөгөөд одоо Алтайн урианхайчууд Баян-Өлгий аймгийн Буянт, Алтай, Алтанцөгц, Бугат сумдын ихэнх нутагт казакуудтай, Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан сумдын бүх нутгаар дангаараа, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын өмнөд хэсэг, Ногооннуур сумын зарим нутгаар казакуудтай холилдон сууж байна.

Алтайн урианхайчууд Баян-Өлгий аймгийн аль ч сумдад хүн амын олонх болж чадахгүй болсон нь өнгөрсөн зууны эхнээс 1960-аад он хүртэл казакууд олноор нүүдэллэн ирж суурьшсан, урианхайчуудын хагасаас илүү нь улс орны төв ба дорнод хэсэг рүү шилжин суурьшсанаар

тайлбарлагдана. Мөн нэлээд олон урианхайчууд Өлгий, Ховд хотод суурьшчээ. Сүүлийн жилүүдэд урианхайчуудын гадагш шилжин нүүх эрчим бага зэрэг буурах хандлага ажиглагдах болсон. Алтай урианхайчууд тун богино хугацаанд уугуул нутагтаа үндэсний цөөнх болон хувирч, 1979 он хүртэл эрчимтэй шилжин нүүж байв. Урианхайчуудын шилжих хөдөлгөөний нэг онцлог нь тэд төрөлх нутгаасаа өрх бүлээрээ, ойр төрөл саднаараа, гол усаараа шилжин нүүж байснаараа бусад угсаатнуудаас өвөрмөц юм.

Алтайн урианхайн ярианы аялгуу ойродын бусад угсаатныхыг бодвол халх аялгуунд харьцангуй ойр байсан, улс орны төв хэсэгт олноор суурьшиж байсан, халх аялгуунд ууссан гэсэн хоёр гол шалтгааны улмаас урианхайчууд халх гэж бүртгүүлэх нь эрс өссөн учир урианхайчуудын нийт тооны өсөлт бага /34 жилд дөнгөж 49%/ байсан. Урианхайчуудын нийт хүн амд эзлэх хувийн жин 1,9-1,2% болж буурсан тоо мэдээ гардаг. Судалгааны ажиглалт, харьцуулалтаас үзэхэд урианхайчууд олон хүүхэдтэй байдаг тул урианхайн тооны өсөлт улсын дунджаас багагүй байна.

Ховд аймгийн Булган суманд 8 мянга гаруй хавтгай дөрвөлжин километр нутагт **торгууд** нарын 1/3 нь болох 7,5 мянган хүн оршин суудаг ба тэдний хагасаас илүү нь сумынхаа төвд төвлөрснөөрөө бусад угсаатнаас ялгардаг. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Ховд хот, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймагт 2,5 мянган торгууд нар шилжин суурьшжээ. Торгууд нарын 1/3-с илүү нь хятадад харьяалагдаж буй нутгаас өнгөрсөн зуунд шилжин ирэгсэд, тэдний үр хүүхэд юм.

Өнгөрсөн зууны эхээр одоогийн Баян-Өлгий аймгийн Баяннуур, Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн сумдын нутгийг нэлэнхүйд нь эзэмшин нутаглаж байсан **өөлдүүд** одоо уг нутгийн 40-өөд хувь буюу Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд суудаг. Өөлдүүдийн бараг 60-аад хувь нь Ховд, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Төв, Сэлэнгэ аймагт ирж суурьшжээ. Архангай аймгийн Өлзийт, Хотонт сумдад 1690-ээд оны үед ирж суурьшсан өөлдүүдийн удам хэдэн зуун хүн оршин суух бөгөөд тэдний ярианы аялгуу халхчуудынхаас ялгагдахгүй болжээ. Ер нь нийт өөлд нарын дотор халх гэж бүртгүүлэх явдал түгээмэл байна.

Хөвсгөл аймгийн Баянзүрх, Ренчинлхүмбэ /Ханх хороо оролгүйгээр/ Улаан-Уул, Цагааннуур сумдын нийтдээ 25 мянган хавтгай дөрвөлжин километр нутагт 9 мянга гаруй **дархадууд** оршин суух ба хүн амын нягтшил харьцангуй сийрэг байна. Энэ нутагт ажиллах хүчин хүрэлцээтэй байсан учраас нэлээд хүн шилжин суурьшиж, одоо Мөрөн, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Төв, Сэлэнгэ, Дорнод аймагт 5,5 мянган дархадууд оршин сууж байна. Дархад аялгуу халх аялгуутай харьцангуй ойролцоо байдгаас уламжлан 1956 онд дархадуудыг халхчуудад оруулан тоолсон тул тухайн үеэс хойш өссөн байдлыг бусад угсааныхантай харьцуулахад учир дутагдалтай боловч 1963-1989 онд улсын хүн ам 96% өсөж байхад дархадуудын өсөлт 86% байсан нь улсын дундажтай ойролцоо байна.

Ховд аймгийн Мянгад суманд 3 мянга гаруй хавтгай дөрвөлжин километр нутагт 3,5 мянга гаруй **мянгадууд** оршин сууж байна. Ховд, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Төв, Сэлэнгэ аймагт 1,5 мянга шахам мянгадууд шилжин суурьшжээ. Шилжин суурьшсан мянгадууд халх гэж бүртгүүлэх нь

нэлээд дэлгэрч, улсын хүн амд мянгадуудын эзлэх хувийн жин нэлээд багасчээ.

**Үзэмчин** нар 2,1 болохоос 2/3 нь Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд 10 гаруй хувь нь, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Чойбалсан сум, Улаанбаатар Баруун-Урт хотод шилжин суурьшиж, халх гэж бүртгүүлэх нь өссөн уяир 1955-1989 онд хүн ам нь өсөөгүй мэт харагддаг.

**Барга** нар нийтдээ 2,2 мянга болохоос 2/3 нь Дорнод аймгийн Гурванзагал суманд, бусад нь Чойбалсан, Улаанбаатар хотод шилжин суурьшиж, халх гэж бүртгүүлэх явдал өссөн, цөөн хүүхэдтэй, дээд боловсролтой хүн амын тоо нэмэгдсэнээс улбаалан улсын нийт хүн амд баргуудын эзлэх хувийн жин сүүлийн 33 жилд 2,5 дахин багассан. Тоо бүртгэлээс харвал барга нар 1958 онд 2458 байснаа 1989 онд 2130 болж буурсан нь монгол угсаатнаас хүн амын тоо буурсан цорын ганц угсаатан мэт харагддаг.

Монгол дахь түрэг хэлтний хамгийн олонх нь буюу **казакууд** 1868 онд Алтайн нуруунд /ард нь/ зусах болсноос хойш урианхайн ноёдоос бэлчээр түрээслэн нутаглаж байгаад, 1921 оноос байнга суурьшиж, нутаглах эрхтэй болжээ. 1960-аад он хүртэл олон мянган казакууд хилийн цаанаас ирж суурьшсан, үндэсний онцлогоо харгалзан хүүхэд олонтой байх заншлаа сайтар хадгалсан зэрэг шалтгааны нөлөөгөөр хүн ам нь хурдан өсөж, 1989 оны хүн амын тооллогоор улсын хүн амын 6,1%-г эзлэх болов. Одоогийн байдлаар казакууд Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын бүх нутаг, Толбо, Дэлүүн, Булган, Баяннуур, Сагсай сумын ихэнх нутаг, Толбо, Алтанцөгц сумдын нэлээд нутагт урианхай нартай, Баяннуур суманд өөлд нартай, Цэнгэл суманд тува-урианхай нартай, Ногооннуур суманд Дөрвөдүүдтэй холилдон нутаглана. Мөн Ховд аймгийн Булган суманд цөөн тооны казакууд бий. Казакуудын 18-19 хувь нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Ховд хот, Төв, Сэлэнгэ, Хэнтий, Булган аймагт шилжин суурьшсан байв. /1989 он/ 1990-ээд оноос өмнө казакуудын тоо хурдан өсөж байсан ба 1956 онд казакуудын тоо 36,7 мянга байснаа 1989 онд 120,5 мянга болж 328% өссөн нь улсын хүн амын өсөлтөөс нэг дахин, урианхайчуудын өсөлтөөс 4 дахин хурдан өссөн байв. Харин 1990 оны эцсээс Казакстанд хөдөлмөрийн гэрээгээр шилжин ажиллах болж, 1990-1994 онд 64 мянган хүн Казакстанд очсон байна. Эдгээрийн дотор хөдөлмөрийн насны 20 мянган хүн байна. Тэд таван жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бөгөөд Монголд буцаж ирэх, Казакстаны иргэн болох зэрэг асуудлуудыг яаран шийдэхгүй болгоомжтой хандаж байна. Монгол оронд эдийн засгийн хямрал уналт болж ажилгүйдэл ихэссэн, ерөнхий боловсролын сургуульд уйгаржин бичгээр хичээллэх болсон зэрэг нь казак иргэдийг шилжин суухад голлон нөлөөлсөн юм. Баян-Өлгийн казак иргэдийн 1/4, Ховдын казак иргэдийн 40% бусад аймаг, хотод оршин сууж байсан казакуудын 4/5 нь Казакстанд ажиллахаар явсан байна. Одоо манай улсад 80 мянга гаруй казакууд оршин сууж байгаагийн 85% нь Баян-Өлгий, 5% нь Ховд аймагт, 10-аад хувь нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Төв, Сэлэнгэ аймагт оршин сууж байна.

Монгол газар оршин сууж байгаа түрэг хэлний нэг угсаатан бол **хотончууд** юм. Хотончууд нь Увс аймгийн Тариалан суманд зонхилон амьдрахын зэрэгцээ зэргэлдээ орших Наранбулаг сум болон бусад аймаг, сумдад цөөн тоотой амьдардаг. Монголын хүн амын дунд багахан хувийг эзэлдэг /0,3%/

хотончуудын угсаа гарлыг олон түүхч, угсаатны зүйчид, түүхэн талаас нь судалж, өөр өөр дүгнэлт гаргаж байсан боловч одоо хүртэл энэ асуудал маргаантай хэвээр байгаа юм.

Хотончууд эртнээс голчлон газар тариалан эрхэлж, арвай, хөх тариа, улаан буудай тариалдаг ба голлон арвайг ихээр тариалж, түүнийгээ гар аргаар боловсруулан хүнсний гол бүтээгдэхүүн болгон хэрэглэдэг байна.

Хотон угсаатны шилжих хөдөлгөөний чиглэл нь ерөнхийдөө засаг захиргаа, соёл, боловсрол төвлөрсөн төв суурин руу голлон чиглэсэн байдаг.

Багуудын хэмжээнд гарч буй шулуун шилжилтийг орж ирж буй сөрөг шилжилттэй харьцуулахад 5,5 дахин их байгаа нь багууд харьцангуй тусгаарлагдмал байдалд орсныг харуулж байна.

Сумын төвд орж ирж буй сөрөг миграцийг гарч буй шулуун миграцид харьцуулахад сөрөг шилжилт нь шулуун шилжилтээсээ 752,93 дахин их байна. Энэ нь сумын төвийн популяци багуудаас шилжин ирсэн хүмүүсээс бүрдсэн үүсмэл популяци болохыг харуулж байна.

Улаангом хотод 1000 гаруй хотонгууд суурьшжээ. Улс орны төв хэсэг, хотуудад ойролцоогоор нэг мянга орчим хотонгууд суурьшсан хотонгуудын 15 %-г эзэдж байна. Идээшсэн нутгаасаа шилжин суурьших талаараа хотончууд нь Монголын бүх угсаатан, ястнаас хамгийн бага байдгаараа онцлогтой. Хотончуудын тооны өсөлт улсын дундажтай ойролцоо түвшинд байна.

Хотон угсаатны популяцид гаднаас орж ирсэн 52 иммигрант байгаа нь бараг бүгд сумын төвийн дэд популяци руу чиглэсэн байна. Хил залгаа оршдог Бөхмөрөн, Ховд, Өмнөговьд сумдаас 39, зэргэлдээ орших Зүүнхангай, Давст, Тэс сумдаас 8, алслагдсан аймаг болох Завхан аймгийн Булнай сумаас 8 хүн гаднаас шилжин иржээ.

Гарал, үүслийн талаас нь тува-урианхай нарыг түрэг угсаанд багтаадаг. Баян-Өлгийн аймгийн Цэнгэл, Ойгор, Цагаангол сумдын нутгийг Цэнгэл, Улаанхус сумдын нутагтай нийлүүлэхэд, тува урианхай нар Цэнгэл суманд бөөгнөрөн нутаглах болжээ. 1960-аад оны сүүлээс казакууд лоноор ирж суурьших болсноос тува-урианхай нарын бараг хагас нь улс орны тэв хэсэгт ирж суурьшжээ.

1980-аад оны дунд үе хүртэл Цэнгэлийн тува-урианхайчууд өөрсдийгөө монголчууд гэх нь зонхилж байв. Харин сүүлийн жилүүдэд тува гэх болсон. Одоо Цэнгэлд 2 мянга орчим тува-урианхайчууд оршин сууж байна. Цэнгэлд оршин суугаа тува-урианхайчууд казакуудтай казак хэлээр ярьдаг. Одоогийн Баян-Өлгий аймагт нутаглаж байгаад, 1920-оод оноос хилийн цаана буюу Алтайн нурууны өврөөр шилжин нутагласан тува-урианхай нараас 400 гаруй хүн 1950-1960-аад онд Ховд аймгийн Буянт суманд ирж суурьшжээ. Манай улсын хүн амын тооллого, бүртгэлд Алтайн урианхай, ариг урианхай /хөвсгөлийн/, тува /цаатан/, тува-урианхай нарыг бүгдийг нь урианхай гэж нэг угсаанд бүртгэдэг нь судалгаанд нэлээд бэрхшээл учруулдаг.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын уул тайгаар **цаатан** хэмээн нэрлэгддэг тува-урианхай нар нутаглана. Цаатан гэдэг нь цагаан бугатан гэсэн үгний товчлогдсон дуудлага юм. Гэрийн цаа буга нь цайвар цагаан өнгөтэй байдгаас энэ нэр үүсчээ. Хилийн шугам өөрчлөгдөж, Тарисын рашааны хавь нутаг, Долоон хөшиг, Тэнгис нурууд, Билимийн хөндий хилийн цаана үлдэх болсны улмаас тэнд нутаглаж байсан цаатан нар Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Ренчинлхүмбэ суманд шилжин ирж суурьшсан юм.

Тэр үед амьдрал нэн ядуу, анх нүүж ирэх үед 300 гаруйхан цаатай, 150-200 хүн шилжин ирж суурьшсан бол одоо 1400 гаруй цаатай, 30 гаруй цаатан өрхөд 200 гаруй хүн тайгад аж төрж байна. Мөн Цагааннуур, Улаан-Уул сумын төвд 150 шахам, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймагт 100 шахам цаатангууд оршин сууж байна. Цаатангууд өөр хоорондоо тува хэлээр, бусадтай монгол хэлээр ярилцдаг. Улаан-Уул сумын цаатнуудыг баруун тайгын, Ренчинлхүмбэ сумынхныг зүүн тайгын цаатангууд гэдэг.

1980-аад оны эхээр Цагааннуур сумыг байгуулахад Улаан-Уул сумын баруун тайгынхан Цагааннуур суманд шилжин суурьшжээ. Манай улсад одоо нийтдээ 500 шахам цаатнууд оршин суудаг. Цаа малладаг хүмүүсийн дотор дархад, халх, дөрвөд хүмүүс ч бий.

Монгол улсад олон арван жилийн туршид нэлээд тооны орос, хятад оршин сууж байв. 19-р зууны сүүлээс Манж Чин улсын төр буурч, хятад түшмэдүүдийн эрх давамгайлах болж, тэд Монголд Хятад иргэдийг суурьшуулах бодлого явуулан, 1890-ээд оноос 1910 он хүртэл хугацаанд багцаагаар 30 мянга орчим хятадыг суурьшуулжээ.

1915-1919 онд “Монголор” алтны алтны уурхайд ажиллуулах, тариа тарих, наймааг өргөжүүлэх нэрээр цэргийн насны эрэгтэйчүүд зонхилсон олон Хятадыг Монголд түлхэн оруулав. 1918 оны хүн амын тооллогын бүрэн бус мэдээгээр 100 мянга орчим Хятад Монголд байсан. Монголд Хятадын нөлөө ихэссэнийг Орос улс зүгээр харж суусангүй. Ерөө, Хараа голын савд тариачид, худалдаачид суурьшихыг дэмжсэнээр Хүдэр, Булагтай, Ерөө, Мандал, Хараа, Бургалтай зэрэг газарт Орос суурингууд бий болж, оросуудын тоо 1918 он гэхэд 5000 хүрчээ. Нийслэл хүрээнд хятад, оросууд олноор суурьшив. 1921 оны хувьсгалын үеэр Монголд байсан хятадуудын тоо барагцаалбал 2 дахин цөөрсөн. Харин 1920-оод оноос оросуудын тоо өсөж эхэлсэн.

1950-аад оны сүүл үеэс 1964 он хүртэл хөдөлмөрийн гэрээгээр Монголд ажиллах Хятадуудын тоо 40 мянгад хүрэв. 1956 оны тооллогоор хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллаж байсан орос, хятадыг оруулахгүйгээр тус улсад 13,4 мянган орос, 16,2 мянган хятад оршин сууж байснаа 1963 онд оросууд 8,9 мянга болон цөөрч, хятадууд 22 мянга болж нэмэгдэв. 1960-аад оны дунд үеэс хятад оросуудыг нутагт нь буцаах бодлогыг зөөлөвтөр, шургуу явуулсны дүнд Монголд оршин суух орос, хятадуудын тоо мэдэгдэхүйц цөөрч, 1969 оны тооллогоор орос 1,4 мянга, хятад 0,7 мянга болж, улмаар 1989 онд орос 140, хятад 247 болж цөөрсөн байна.

1970-1990 оны хооронд хөдөлмөрийн гэрээгээр Монголд ажиллаж байсан ЗХУ-н иргэд, тэдний гэр бүлийн хүмүүсийн тоо жил бүр 30 мянгад эргэлдэж байв. 1990 оноос хойш Монголд оршин суух гадаадын иргэдийн /ялангуяа



хятад, оросын харьяат нар/ тоо хурдан нэмэгдэж байв. Одоо манай улсад түр ажиллаж байгаа оросын иргэд 6 мянга, хятадын иргэд 8 мянга орчим байна. /албан бус мэдээ/ Гадаадын харьяат нар хүн амд нь хамгийн бага хувийн эзэлдэг орнуудын тоонд Монгол Улс хамрагдана. Хойшид энэ харьцааг тодорхой хэмжээнд барьж байх шаардлагатайг судлаачид нотолдог.

Гадаадын харьяат нарын 95 гаруй хувь нь Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Зүүнхараа хотод оршин суудаг.

Хөдөө угсаатан ястнууд холилдон нутагших нь харьцангуй бага, тус тусын нутагшлын дүр төрхийг үүсгэн оршин суудаг. Харин томхон хотууд олон угсаатан ястны бөөгнөрлийн төв болохын хувьд угсаатан ойртон нягтрах явцад ихээхэн үүрэг гүйцэтгэж байна.

Нийслэл Улаанбаатар хотод улсын хүн амын 25% нь /өдөр тутмын эргэлтээр 30-33% нь/ оршин суух бөгөөд олон угсаатан ястны нэлээд хэсэг нь төвлөрсөн байна. Улаанбаатар /Налайх, Багануурын хамт/ хотын хүн амд халх 80%, буриад 3.5%, дөрвөд 2.5%, казак 1%, баяд 2%, урианхай, захчин, дариганга тус бүр 0.5%, өөлд, торгууд тус бүр 0.4%, дархад, мянгад, барга тус бүр 0.1, хятад 0.3, бусад үндэстэн 0.4 % тус тус амьдарч байна.

Олон угсаатан ястан төвлөрөн суудаг хотуудын нэг бол Ховд хот юм. Хүн амын 93% нь монгол угсаатан, 6.5% нь түрэг угсаатан байгаагаас халх 49, өөлд 17, захчин 10, урианхай 5, мянгад 5, дөрвөд 3, торгууд 2 хувийг тус тус эзэлж байна. Өлгий хотын хүн амд казак 66, дөрвөд 3, урианхай 30, тува-урианхай 1 хувийг эзэлнэ. Улаангом хотын хүн амд халх 20, дөрвөд, хотон нийлээд 46, баяд 34 хувийг эзэлнэ. Чойбалсан, Мөрөн, Дархан, Эрдэнэт, Сүхбаатар, Чойр хотуудад олон угсаатан, ястан оршин суудаг.

Манай улсад угсаатны гадуурхал, харгислал байгаагүй нь олон угсаатан, ястан чөлөөтэй шилжин суурьших, амьдрах, сурах бололцоог нээлттэй болгосон төдийгүй нэгдмэл Монгол үндэстэн бүрэлдэн бэхжих үйл явцад маш их түлхэц болсон юм. Нийгэмд гарч байгаа өөрчлөлттэй болон нийгэм, эдийн засаг, хүн амын хэтийн төлөвтэй уялдуулан, төрийн хүн амын буурьтай бодлого боловсруулах, эдийн засгийг хөгжүүлэх, улс үндэстний оршин тогтнох үндсийг бэхжүүлэх үндэслэлийг сайжруулах зорилгын үүднээс хүн амын байршилт, шилжих хөдөлгөөнийг алсын хараатай судлан, баримтлах чиглэл боловсруулах зайлшгүй шаардлага урган гарч ирээд байна. Энэ ажлыг судалгааны арга барил, туршлага бүхий хүмүүс зонхилсон цөөн хүний бүрэлдэхүүнтэй, сүр дуулиан багатай, тасралтгүй шаргуу ажиллах зарчмаар явуулах шаардлагатай байна.